

**“ҮНДСЭН ХУУЛЬ” БА “СОНГУУЛИЙН ХУУЛЬ” ДАХЬ ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН  
ОРОЛЦООНЫ АСУУДАЛД**

**Ц.БАТБОЛД**

Доктор, дэд проф. МНС. ШУС. Нийгмийн Ухааны Салбар.  
Улс Төр Судлалын тэнхим

**Б.БАТБААТАР**

Докторант

**Түлхүүр үг:** иргэн, иргэний оролцоо, шууд арчилал, нам, сонгох, сонгогдох эрх, үндсэн хууль, сонгуулийн хууль, сонгуулийн санхүүжилт.

**Товч хураангуй:** Үг өгүүлэлд иргэдийн улс төрийн оролцооны бодит байдал, боломж нөхцөлийг “Үндсэн хууль”, бусад хууль тогтоомжууд нэн ялангуяа их хурлын ба орон нутгийн сонгуулийн хуулиудад хэрхэн тусгагдсан талаар дурьдаж. Түүнд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид шийдвэрлэбэл зохих асуудлын талаар онол, практикийн үүднээс авч үзэхийг зорьсон болно.

\*\*\*\*\*

Дэлхий дахинаа төдийгүй, Монгол улсад иргэдийн улс төрийн оролцооны идэвх нь төрөөс баталсан хууль тогтоомж, сонгуулийн үйл явцаас хамааралтай юм. Ж.Ж.Руссог оролцооны талын онолч гэж судлаачдын олонх нь үздэг бөгөөд тэрээр “Нийгмийн Гэрээ” бүтээлдээ улс төрийн тогтолцооны мөн чанарыг ойлгоход оролцоот арчилал нэн чухал хэмээсэн. Түүний онолын цөм нь, улс төрийн шийдвэр гаргах түвшинд болон өөрийн онолын хүрээнд ч хувь иргэн бүрийн оролцоог чухал хэмээн үзсэн байдал. Энэ нь ердөө институцийн байгуулал дээр хавсаргасан нэмэлт биш бөгөөд институциудыг үйл ажиллагаа болон түүнд оролцож байгаа хувь хүмүүсийн сэтгэл зүйн чанар, хандлагын хооронд харилцан хамаарал байгаа гэдгийг баталсан төдийгүй, улс төрд оролцогч этгээдүүлэд сэтгэл зүйн нелеөтэй юм.<sup>1</sup>

Оролцооны онолд “улс төрийн” асуудал нь үндэсний болон орон нутгийн засаглалын хүрээгээр хязгаарлагддаггүй. Оролцооны онолд “оролцоо” гэдгээр шийдвэр гаргах үйл явцад талууд(тэгш) оролцохыг хэлдэг. “Улс төрийн тэгш байдал” гэдгээр шийдвэрийн үр дүнг тодорхойлоход ижил эрх мэдэлтэй байхыг ойлгодог. Өөрөөр хэлбэл, нэг хүн нэг санал гэсэн санаа бөгөөд ямар нэг асуудлаар санал хураахад удирдагч давуу эрх эдэлхүүгийг гэсэн үг. Санал хураах явцад дээр дурьдсаннаар сэтгэл зүйн болон бусад хамаарал нелеөлдөг бөгөөд тухайлбал, удирдагч эрх мэдэлтэнг дагах үйл явц ч ажиглагддаг. Энэ нь хувь хүнийёс суртахуун, хүмүүжил, иргэний боловсрол, улс төрийн ухамсарын төлөвшил болон бие дааж шийдвэр гаргах чадвараас хамааралтай төдийгүй тэдний ахуй байдал, ашиг сонирхол нь ч үүнд нелеөлөх гол хүчин зүйлийн нэг болдог.

Оролцоот арчиллын онолын судалгааны хүрээнд гарсан мэргэжлийн судлаачдын судалгааны болон онолын бүтээлүүдийг төр засгийн шийдвэр гаргах түвшний эрх мэдэлтүүд анхааралтай судлах нь чухал бөгөөд тэдний шийдвэрт ихээхэн ач холбогдолтой. Энэ хүрээнд хувь иргэний болон иргэний нийгмийн байгууллагууд түүн дотроо иргэний хөдөлгөөнүүдийн үйл ажиллагаа, тэдгээрийн идэвхжил, намжмал байдал, зорилго чиглэл, нийгэмж болон эрх баригчдад нелеөлөх нелеөллийг судлах нь чухал юм. Үүний зэрэгшээгээр оролцооны арчилалд нелеөлөх бусад хандлагуудыг тухайлбал, эрх баригчид болон бизнесийн тодорхой ашиг сонирхлын бүлэглэлүүд (жишээ нь үндэстэн дамнаасан корпорациуд, уул уурхайн компаниуд)-ийн зүгээс иргэний нийгмийн байгууллага, хөдөлгөөнүүдийнзорилго чиг хандлагыг өөрчилж, өөредийн эрх ашигт нийцүүлэхийг эрмээзэх, тэдгээрийн удирдагчдыг элсүүлэн авах(тэднийг ажлын байр, эрх мэдэл, албан тушаал амлах, хөрөнгө менгөөр хахуульдах зэрээр урвуулах) бодлого хэрэгжүүлдэг арга замуудыг нь ч онцгойлон судлах шаардлагатай. Ингэснээр арчиллын нөхцөлд үлс орны хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход улс төрийн оролцооны чухал ач холбогдлыг зөв оновчтой тодорхойлох боломж бүрдэнэ.

Иргэний хөдөлгөөний үүсэл хөгжил нь төр, нийгмийн харилцаа үүссэн үеэс эхлэлтэй гэж үзвэл, нийгэмшилтийн үйл явцад хэн захирагдах ёстой вэ гэдэгт асуудлын гол нь бус, харин захирагч нь ямар шийдвэр гаргаж, тэр нь нийгмийн олонхид хэрхэн зөрөг болон серөг нелөө үзүүлэж байна вэ гэдэг нь асуудал юм. Иргэний оролцоо нь шийдвэр гаргах үйл явцад өөрсдийн саналаа тусгах төдийгүй буруу шийдвэр гарахаас урьдчилан сэргийтж хамгаалсан хяналтыг тогтоодог гэж үзэх үндэснээлтэй. Иргэдийн оролцооны гол зорилго нь шийдвэр гаргах түвшинд өөрөө очихыг зорьдоггүй бөгөөд зөвхөн зөв шийдвэр гарахад нелеөлөх нелеөлөл гэдгээрээ институцилэгдсэн байгууллагуудаас ялгаатай байдас.

<sup>1</sup> К.Пейтман “Ж.Ж.Русс. Ж.С. Милл.Ж.Б.Х.Коу: Арчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батбод. УБ 2012. Х 180-185

Ж.Ж.Руссогийн “Нийгмийн гэрээ”-нд, хүмүүст биш хуулинд захирагдах ёстой гэдгийг төгөлдөржүүлсэн гэдэг ч. үүнээс илүүтэйгээр хүмүүс өөрсднийхөө зохион бүтээсэн нийгэм, улс төрийн зүй тогтолцоо захирагддаг. энэ нь өөрөө хүмүүсийн засаглалыг урьдчилсан нөхцөлдүүлж байдаг гэдгийг нарийвчлан томъёолсон юм. Яагаад гэвэл, иргэн хүн нь биээ даасан хувь хүн бөгөөд сонгууль өгөх, өөрийн гэсэн үзэл бодолтой байх тал дээр хараат бус болохынхоо хувьд өөрөөсөө өөр хэн нэгэнд илүү ашигтай нөхцөл байдлын телөө саналаа өгөх албагүй. Х-хувь хүн зөвхөн Х-д ашигтай байх зорилгын төлөө хэн нэгнийг өөрт санал өгүүлэхээр албадаж болохгүй.<sup>2</sup>

Монгол улсад арчилсан нийгмийг байгуулах үйл явц 24 дэх жилийгээ золгож буй бөгөөд “Үндээн Хууль”-тай болж хүмүүнлэг иргэний арчилсан нийгэм байгуулахаа дэлхийд тунхаглан зарласан билээ. Энэ хугацаанд бид хүний эрх, эрх чөлөөний тухай, арчилсан шударга сонгууль, хувийн өмчийн тухай, чөлөөт өрсөлдөөний тухай, уг хэлэх, хэвлэн нийтгэх эрх гээд олон арван өөрчлөлтүүдийн тухай мэддэг болж түүнийгээ хэрэгжүүлэхээр тэмцэж өрсэн. Арчилсан хүн өвсгал, түүний дараах нийгмийн шилжилтийн үеийн хүндэрэлийгарл түмэн хүлээнтэй, тэвччэртэйгээр даван туулсан. Бидний туулсан замнал, аливаа дувьсгал хийгээд тэмцэл ялалтын алдаа, оног шүүн тунгаах ахул гагцхүү санаачлагч манлайлагчдын хийсэн гавьяя зүтгэл болон тэдний хийж бүтээсэн өмч биш бөгөөд энэ нь итгэл үнэмшил. Үнэн сэтгээлээр дэмжсэнолон түмний оролцооны гавьяа хийгээд ял мен болой.

Аливаа үйл хэрэг саад тогтор үгүй замаар явдаггүйн адиллаар энэ хугацаанд алдаа завхрал гарсаар байна. Эдгээрийн нэг нь сонгуулийн хуулиудад байгаа зарим зүйл заалтууд нь “Үндээн хууль” болон арчиллын зарчмуудыг зөрчсөн байна хэмээн авч үзэхийг энэ өгүүлэлд зорьсон билээ,

Монгол улсад иргэдийн оролцоо нь бүх шатны сонгуульд оролцох санал өгөх, нэр дэвших, төрийн дээд засаглал болон өөрийн нутгийн удирдлагын байгууллагад төрийн алба хаших, төрд хандах зэрэг хэлбэрээр “Үндээн хууль”-д заасан эрх эдлэх боломж байдал хэдий ч энэ нь бусад дагавар хуулиудаар (тухайлбал сонгуулийн хуульд энэхүү эрхэнд саад учруулах шууд бусаар) нөлөөлөх зүйл заалт тусгагдсан байна. Монголын сонгогчид 1990 оны арчилсан хувьсагдаас хойш УИХ. Ерөнхийлөгчийн, Орон нутгийн ИТХ –ын гэх зэрэг нийтдээ 17 удаагийн арчилсан сонгуульд оролцсон байна.

Үндээн хуулийн 1.3.1 “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулен төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ здлэнэ.” гэжээ. Гэтэл Сонгуулийн Тухай Хуулиудын зарим зүйл заалтууд нь Монгол Улсын Үндээн Хуулийг зөрчсөн гэх үндэслэл байна.

#### Үнд:

Нэг. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн Тухай Хуулийн 7.2. “Энэ хуулийн 6.2-т заасан иргэн сонгуулийн нэг тойргийн 801-ээс доошгүй сонгоочийн бээмжтэг авсан нөхцөлөө тухайн сонгуулийн тойргот Улсын Их Хурлын гишүүн нэрээ бие даанэвшигүүлжэхэрхтэй.” гэсэн заалт нь: Үндээн хуулийн Нэгдүгээр бүлгийн 3.1. Гурав дугаар бүлгийн 21.2 дахь заалттай зөрчилдэж байгаа төдийгүй. Улс Төрийн Намын тухай хуулийн “9.3.7 Намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл 70овог, эцгийн болон өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, гарын үсэг” гэсэн зүйл заалттай ижил утгатай давхаасан заалт болж байна. Учир нь: Монгол Улсын иргэн нь УИХ-д нэрээ дэвшүүлж байгаа бөгөөд нам байгуулах гээгүй юм. Мөн хуулийн 28 дугаар зүйл заалт бүхэлдээ... зөрчилтэй байна. Ж.Ж.Руссогийн үзсэнээр “оролцоогүй институциунд тийм заналхийллийг авчирдаг бөгөөд, хүмүүсийг “гинжилж” эрх чөлөөг нь боодог.”<sup>3</sup>

Хоёр. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн Тухай Хууль-ийн Нэгдүгээр бүлгийн 5.1. Зургаадугаар бүлгийн 26.2, 26.3, 26.4, 26.5 дугаар заалтууд улс төрийн, эрх баригчдын эрх ашгийг илүү хангасан байна. Ж.С.Милл: “Арчилал дахь хамгийн том аюул бол эрх баригчдын хөөнөөлтэй хүсэл зорилго байдаг. Хариулт нь нэхэгдсэн хамгийн чухал асуулт гэвэл, ийм мянгаасын өөдөөс ямар хамгаалалт байна вэ гэдэг л байна” гэж төлөөллийн засгийн газрын тухай яриандаа онцлогчон байна.<sup>4</sup>

<sup>2</sup> К.Лейтман. “Ж.Ж.Руссо, Ж.С. Милл, Ж.Б.Х.Коу: Арчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Ори Ц Батбодл УБ 2012 Х 180-185

<sup>3</sup> К.Лейтман. “Ж.Ж.Руссо, Ж.С. Милл, Ж.Б.Х.Коу: Арчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Ори Ц Батбодл УБ 2012 Х 180-185

<sup>4</sup> Милл(1910) Оршил ба 254-р тал. Дэлгэрэнгүйг Бүрнс 1957)-д үз. “Дункан ба Люк (1963, х. 160) Ул тогтолцооны өөрөө үлдэх чадварыг тэмдэлгэнэ. Гэвч энэ бол орчнүүдийг оролцоонд сургах боломжит хууль ёсны эрхийг эзэмшиж тээвэрлэх үүдэн гарах учраас “бие сургахаарын шинж чанар”-ийн хангилагчтай байна гэж хйтээ. Мэдээж энэ бол зөвхөн сургах асуудал болохоос эзэмшиж тухай бус үзэсгэн Миллний дүгнэлт юм. Оролцооны дэг журам байхгүйгээр хууль ёсны эрхийг эзэмшиж нь шинж чанарын хувьд бага зэрэг нөлөөтэй байж болно

**Гурав.** Аймаг, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн Тухай Хуулийн Зургаа дугаар бүлгийн 27.2, 27.3, 27.4 дэх заалтууд нь Монгол Улсын Үндсэн Хуулийн Тунхаг, мөн хуулийн Нэгдүгээр бүлгийн 3.1, Хоёр дугаар бүлгийн 14.1, 14.2, Гурав дугаар бүлгийн 21.2 дахь заалтууд зөрчилтэй байна.

Аливаа сонгуульд бие даан нэрээ дэвшүүлж байгаа иргэн нь сонгогчдын нэр, хаяг гарын үсгийг Сонгуулийн хорооноос багалсан маягтанд сонгогчдыг урьдчилан бүртгэж тэднээс 801 түүнээс дээш. 500 болон 200, 75 хүний гарын үсгийг зуруулж дэмжлэг авч буй явдал нь нууцаар санал хураах хуулийн заалтыг зөрчиж, урьдчилан санал хурааж иргэдийн санаа бодол, сонгох, сонгогдох эрх чөлөөнд ноцтойгоор халдаж буй явдал төдийгүй ямар нэгэн *нам бүлэглэлд элсээгүйн төлөө шийтгэл*, дарамт шахалт болж байна гэж үзэхээр байгаа ўйл яви бөгөөд, дэмжиж гарын үсэг зурсан иргэнийг мөрдөж *мөнгөж* буй заалт нь мөн л Үндсэн Хуулийг зөрчсөн ўйл ажиллагаа ба эдгээр нэрсийн жагсаалт нь хэн нэгэн эрх мэдэлтэний гарт очсоноор иргэдийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах үндэслэл бий болгох сөрөг талтай байна. Ж.С.Милл “Тэдний ёс суртахууны ур чадвар тэгэх хөгжилгүй байна. Хүн төрөхтний оршин амьдрах нийгмийн орчин нөхцлийг хиймлээр дүрсэлж зурснаар тэдний оюун санаа, сэтгэхүүг нарийсгаж, хөгжлийг нь зогсоно”<sup>5</sup> гэжээ. /1910, х 203-4/ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай Хуулийн 26.5 Нийслэл, Аймаг, Сум, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн Тухай Хууль-ийн 27.4 дэх заалтууд нь “Үндсэн Хууль”-ийн Хоёрдугаар бүлгийн 16.13-т заасан “Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй.....-мердэн мешгих, эрх чөлөө нь хязгаарлахыг хориглоно гэсэн заалтуудыг ноцтойгоор зөрчиж байна гэж үзэх үндэслэл байна. Ж.С.Миллардчилал бол орчин үеийн дэлхийд салшгүй чухал зүйл бөгөөд гол асуудал нь ардчилсан улс төрийн хууль журмыг нийгмийн “жинхэнэ” мөн чанартай уялдуулан, энэ дэглэмд хэрхэн “олонхий”-ыг хамруулах ажлыг зохион байгуулах явдал юмгэж үзсэн байна.<sup>6</sup>

Дээрх асуудалтай колбогдуулан иргэдийн оролцооны чухал үзүүлэлтийн нэг нь УИХ болон орон нутгийн ИТХ-д нэр дэвшиж сонгогдсон байдал буюу шийдвэр гаргах түвшинд хүрч чадсан байдлыг нэг үзүүлэлт гэж үзвэл, дараах хүснэгтуүдэд анхаарлаа хандуулна уу.

Иргэдийн оролцооны байдлыг сонгуульд нэр дэвшиж санал авсан байдлаар авч үзвэл:

УИХ-ын сонгуульд сонгогдсон байдлаар:

Хүснэгт I

Сонгуулийн жил	МАХН		Ардчилсан эвсэл		Бие даагч гишүүд	
	хувь	суудлын тоо	хувь	суудлын тоо	хувь	суудлын тоо
1992	59,6%	71	40,0%	4	0,4%	1
1996	40,5%	25	47,0%	50	0,9%	0
2000	51,6%	72	13,4%	1	0,0%	0
2004	48,3%	37	44,3%	35	0,0%	0
2008	51,3%	39	34,2%	26	0,4%	1
2012	32,8%	25	57,8%	44	4,7%	3

**НИЙТ СОНГОГДСОН ГИШҮҮД 456 ҮҮНЭЭС БИЕ ДААГЧИД НЬ 5 ГИШҮҮН БҮЮУ 0,01%**

Дээрхи хүснэгтэд үл ялиг ахисан үзүүлэлт харагдаж байгаа боловч нийт мандатын тоотой харьцуулахад ахиц дэвшил гаралаагүй гэж үзэхээр байна. УИХ-н хуулиар 8-с дээш гишиг нэгдэж байж бүлэг байгуулах эрхтэй.

**Нийслэл болон дүүргүүдийн ИТХ-д санал авсан байдлаар:**

Энэ хүснэгтэд 1992-2012 онуудад явагдсан 7 удаагийн сонгуулийн НИТХ, БЗ, СБ, СХ, ЧД-ээс авсан судалгаа багтсан болно. Энд анхаарах нэг зүйл бол тухайн хороо, дүүрэгт огт амьдардаггүй хүн нийслэл, дүүргийн ИТХ-д сууж байгаа явдал юм. 1992 оны шинэ Үндсэн Хууль батлагдаж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) гэсэн шинэ байгууллага бий болсон. Энэ нь сонгодог утгаараа бол цэвэр орон нутгийн тэнд оршин суух иргэдийн, иргэний төлөөллийн байгууллага юм.

<sup>5</sup> К.Пейтман, “Ж.С.Руссо, Ж.С. Милл Ж.Б.Х.Коу: Ардчиллын оролцооны онол”/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичит/ Орч Ц.Батболд.УБ, 2012. Х 180-185

<sup>6</sup> Ж.С.Милл (1963, х. 17). Милл нь энэ үзэл тайлбарыг өмнөх хувилбартаай нь харьцуулсан ба хуучин сургааль, дэг жаягт бичигдсэн “шилжилт”-ийн тухай энэ тайлбарт “олонхи ямар нэгэн удирдан чиглүүлэх зүйлгүйгээр цаашдаа вөрслийн нтээ найдварын замаа алдана” гэсэн байдал. (х. 3).

Сонгуулжийн ийн	Нийт ийн		БЗД		СХД		СБД		ЧД		Нийт суудлын тоо
	намууд	Бие даагч	намууд	Бие даагч	намууд	Бие даагч	намууд	Бие даагч	намууд	Бие даагч	
	Хүчинчтэй 2										
1992	шний	72	-	-	64	36	-	-	61	34	
1994	-	-	-	-	62	38	-	-	67	23	
1996	39	1	35	0	34	1	-	-	35	0	
2000	-	-	35	0	35	0	35	0	35	0	
2004	39	1	35	0	35	0	35	0	32	0	
2008	39	0	35	0	34	0	35	0	35	0	
2012	45	0	41	0	41	0	35	0	-	-	

Тайлбар : Уг судалгааг судлаач албан хүснэгтээр (бичгээр ) Нийсдэл, түүний төвийн 6-и дүүрэгт хандаж хургуулсан ба харин гэж гаргасан болно.

#### Аймгийн ИТХ-ын сонгуулийн 2012 оны эзлжигт сонгуулийн санал авсан дүн

Хүчинчтэй 3

Аймгийн ирр	Нийт мандатын тоо	МАН	АН	Шудрага ёс зөвлө	ИЗИН	Иргэний шудрага зөвлө	Бие даагч
Архангай	37	16	20	МАХН-1			
Баян-Олгий	33	12	20	Шудрага ёс зөвлө-1			
Баянхонгор	41	15	25	МАХН-1			
Бүлган	33	14	17	МАХН-2			
Говь-Алтай	35	21	12				2
Говьсүмбэр	17	9	7	МАХИ-1			
Дорноговь	27	10	16	МАХН-1			
Дорнод	35	18	14	ИЗИН-1			?
Дундговь	35	19	15	МАХИ-1			
Завхан	41	28	13				
Овхорхангай	41	24	16	Шудрага ёс-1			
Өмнөговь	33	11	21	МАХИ-1			
Сүхбаатар	33	8	25				
Сэлэнгэ	37	20	14	МАХН-3			
Тав	41	18	20	МАХН-3			
Уве	41	15	25	МАХН-1			
Ховд	41	14	26	МАХИ-1			
Хэнтий	39	14	25				
Хөвсөгт	41	23	18				
Дархан -Уул	33	18	11	Шудрага ёс-2			2
Орхон	31	10	19				2
Аймгийн дүн	337	379	14	6	1	0	6
Үзүүлэлт дүн	1040	452	546	6	1	8	6
ИЙНТ ДҮН ХУВЬ	1-4-т	43%	52%	0,05%	0,01	0,07%	0,05%

**2012 оны нийслэлийн гурван дүүрэгтэс бусад зургаан дүүрэгт дахин санал хураалт явагдсан.**(энэ нь сонгуулийн ирийн хүрээгүйгээр тайлбарлагддаг )

**Хүснэгт 4.**

Дүүрэг	Нийт мандатын тоо	МАН	АН	БАСАД	Бие даасаны
Бага нуур	25	13	12		
Бага хангай	17	12	5		
Налайх	25	11	12	МАХИ-2	
Баянгол	41	9	30	2	
Баянзүрх	41	7	32	2	
Сонгинохайрхан	41	22	17	2	
Сүхбаатар	35	15	19	1	
Хан-Уул	33	4	29	2	
Чингэлтэй	35	22	11	2	
Дүүргүүлийн дүн	295	115 дүн 39%	167 дүн 56%	13 дүн 5%	11 3%

Тайлбар: Иргэд сонгогчид сонгуульд оролцохгүй байх буюу абсолютизмын үзэгдлүүд уламжлалтадаа байна. Мөн сонгуустын дахин явагдах үзэгдэл ч байна. Энэ нь хэд хэдэн хүчиний зүйлээс хамааралтай. Үүнд:

- 1 Сонгогчдын итгэл алдартсан /худал амьлалт, хэт их сургачилгаа, хэт их шалтаг барьсан мэдээлэл;
2. Сонгуулийн дүн будлаштдаг байдлаас болж идэвхгүй хандах;
3. Иргэдийн идэвхгүй байдал: Энэ нь тэдний ахуй амьдрал, бичигчид, уламсар зөргээс хамааралтай,
4. Сонгууль өгөсон нь биш тоосон нь ялдаг гэлгийг мэддэг иргэдийн флагиудаа өгч цагаа гардахгүй.
5. Хамгийн ноотой шалтгаан нь эрх баригчдын хүссэн хүн нь саналтаваагүйд байдал. Тийм болохоор тооллогыг будлынүүж дахин сонгууль явагдахад хүргэдэг гэж иргэд үзэг байна.

Дээрхи үзүүлэлтуудээс төвийн дүгнэхэд орон нутгийн сонгуулиудад санал авч сонгогдсон иргэдийн тоо буурсаар ирсэн төдийгүй нийслэлийн хэмжээнд 00 түвшинд очижээ. Энэ нь энэхүү судалгааг чухалчилж авч үзсэн тохиолдолд иргэдийн нийгэм маань зогсогтийн байдалд орсон буюу зарим талаараа "таалал төгссөн" гэмээр байна. Нөгөө талаар намчирхах, бүлэгтэйн нийгэм болсоныг ипотлон харуулж буй үзүүлэлт юм.

#### Хүснэгт 5 Сонгогчдын оролцооны идэвхийн буураат

№	Сонгуулийн тогтолцоо	Сонгуулийн жил	Сонгуулийн тогтолцоо
1	Одоо – алж мажоритар	1992	95,4%
2	Нэг мандаттай мажоритар	1996	92,1%
3	Нэг мандаттай мажоритар	2000	82,5%
4	Нэг мандаттай мажоритар	2004	82,2%
5	Олон мандаттай мажоритар	2008	76,46%
6	Хөгжлийн тогтолцоо	2012	67,23%

Сонгуулийн хорооноог сонгогчидын ирийн бүрдүүчэх тал дээр олон ариа хэмжээ авсан ба 2012 оны сонгуулийг ажлын едэр явуулсан, утасны нэгж үнэгүй тараасан боловч үр дүн гэраагүй. Имэр нэгэн нөхөнөхөл күчин зүйлтээр буюу механик аргаар үр дүнгүүд хүргэхгүй энэ удаагийн сонгууль ипотсон.

Очижхүрээгийн Түнгэлдэг 2012 он "Иргэдийн Төлөвлөгчийн Хурал-Лүүгийн холбоотой зарим асуудлууд" номын 7-р хуудасад: "Орон цутгийн Хурлын сонгуульд оролцохэд төрийн намын тоо эзлжимт сонгууль бүрт нэмэгдэж, иэр давшигчид ч олон бодж байгаа нь иргэдийн Төлөвлөгчийн Хурлын иэр хүнд осч, эрх мэдлийн хэмжээ оргосож байгаагийн их илрээ гэж хүнс болгоо" гэжээ. Гэвч судлаач миний хувьд үүнтэй санал огтхой ишийлэхгүй байна. ИТХ-ын нэр үүнээс бий хүргэндээ тэнд хувиарлагдаж мөнгөний тоо эдийн засгийн өсөлтийн хэрээр нэмжилж, түүнийг аяран ширүулах эрх нь тухайн орон нутгийн ИТХ. Засаг дарга наарт байдагтай холбон үзэж байна. Син, уу, язгуулсдэх намуудын тоо өссөөр байгаа ч сонгогчдын ирийн буурсаар байхад ИХ-ын иргэдүүдийн тогтолцоо байж таарахгүй юм.

## ДҮГНЭЛТ

УИХ, ИТХ -ийн төлөөлөгчдийн ири нь зөвхөн төсөв батлах, хуваарилах, хуралд өөрийн болон захиалагчийн эдийн засгийн ашиг сонирхолд нийцсэн хууль, тогтоолуудыг батлах явцад өндөр гардаг. Нэгөөтэйгүүр ашиг сонирхлынх нь эсрэг хуулийн төсөл хэлэлцэх үед бас тэд хуралдаа илэвхтэй иргээдэг нь манай улсын эрх баригчдын хэвшмэл үзэгдэл болсон.

Бүх шатны сонгуулийн хороодод хөндлөнгийн хяналт байдаггүй ба МАН, АН намын харьяалтай гишүүдээс бүрддэг.

Хуулийн хэлэлцүүлэгт иргэдийн төлөөллийг оролцуулж байх.

Үндсэн Хуулийн Цэцэд иргэдийн төлөөлэл байдаггүй.

Хороодод Иргэдийн Нийтийн хурлыг зохион байгуулахгүйгээр ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчид, даргыг томилдог.

Сонгуулийн, болон улс төрийн намуудын тухай хууль нь ач холбогдолоороо үндсэн хуультай энэ зэрэгцэхүйц хууль юм. Үндсэн Хууль. Сонгуулийн хууль. Намуудын тухай хуулийг бүх ард түмний оролцоотойгоор өөрчлөх. Учир нь эдгээр хууль нь улс орны бүх хүн ардад нөлөөлөх хүчин зүйл юм.

## НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 2004.
2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2012.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. УБ., 2005.
4. Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хууль. УБ., 2007.
5. Ж.Ядамсүрэн. Сонгуулийн тухай зарим ойлголт, товч тайлбар. УБ., 2008
6. Избирательное право и избирательный процесс в Российской Федерации. Учебник для вузов. ОТв.редактор А.В.Иванченко. М., "Норма". 1999.
7. Аристотель. Улс төр. Орч Б.Даш-Ёндөн. УБ., 2002.
8. Electoral Management Design: The International IDEA Handbook. Stockholm. Sweden. 2006.
9. К.Пейтман. "Ж.Ж.Руссо. Ж.С. Милл. Ж.Б.Х.Коу : Ардчиллын оролцооны онол"/Улс төрийн шинжлэх ухааны дээж бичиг/ Орч Ц.Батболд. УБ. 2012.
10. Ж.Ж.Руссо. Нийгмийн гэрээ ба Улс төрийн эрхийн зарчмууд. УБ., 2002. Соёмбо прингинг ХХК.
11. Н.Ашфорд. 2007. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. Адмон ХХК.